

МОНГОЛ УЛС ДАХЬ МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE CURRENT SITUATION OF MONEY LAUNDERING IN MONGOLIA

Ц.Ням-Очир*

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, бригадын генерал, Дотоод хэргийн их сургуулийн докторант

Nyam-Ochir Ts.

Br. Gen. First deputy commissioner of National police agency Mongolia, Ph.D Candidate, UIA

*Хариуцлагатай зохиогч: nyamochir.ts@police.gov.mn

Хураангуй: Мөнгө угаах гэмт хэрэг үүсэж хөгжсөн түүхийн цаг үе, нөхцөл байдлаас үзэхэд, өндөр хөгжилтэй орнуудын хувьд дэлхий даяар өргөн тархсан хар тамхи, мансуурах бодис худалдаалах, хүний болон зэвсгийн наймаа, газрын баялгийг хууль бусаар олборлох нь мөнгө угаах гэмт явдлын гол хөдөлгөгч хүч болж байдаг. Харин эдийн засгийн хувьд тогтворгүй ядуу буурай, эсхүл жижиг эдийн засагтай, гаднын зээл, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтад тулгуурлан хөгжиж буй орон гадаадын хөрөнгө оруулагчдын мөнгөний эх үүсвэрийг хянах, шалгах боломж хомс улсад мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх нь түгээмэл болохыг олон улсад тогтоосон байна.

Манай улсын хувьд мөнгө угаах гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрч, тухайн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгцээ, шаардлага бий болжээ. Тодруулбал, Монгол Улс дахь статистик мэдээнд “Мөнгө угаах” гэмт хэргийн зүйлчлэлээр 2019-2023 оны хооронд нийт 162 гэмт хэрэг бүртгэгдсэний 14 буюу 8.6 хувийг АТГ, 148 буюу 91.4 хувийг цагдаагийн байгууллага шалгасныг бүртгэгдсэн хугацаагаар нь авч үзвэл 2019 онд 54, 2020 онд 27, 2021 онд 47, 2022 онд 12, 2023 онд 22 (FATF, 2022) гэмт хэрэг тус тус бүртгэгджээ. Иймээс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх арга замын талаар өөрийн санал, дүгнэлтийг гаргахаар энэхүү өгүүллийг бичлээ.

Abstract: Money laundering as a criminal activity has developed over time, influenced by historical periods and circumstances. In developed countries, the main driving forces behind money laundering are the widespread trafficking of illicit drugs, narcotics, human and arms trade, and the illegal extraction of natural resources. In contrast, in economically unstable, poor, or small economies, where development relies heavily on foreign loans, grants, and investments, the lack of control and oversight over the sources of foreign capital makes money laundering crimes more prevalent. This has been confirmed globally.

In our country, the situation regarding transnational money laundering crimes has worsened, leading to the need for intensified efforts to combat such crimes. This is evident from the National Risk Assessment Report on money laundering and terrorist financing conducted by Mongolia in 2016, the analysis of money laundering crimes registered and investigated by law enforcement, and the information obtained through the follow-up actions. For example, a total of 162 money laundering crimes were registered under Article 18.6 "Money Laundering" of the Criminal Code of Mongolia from 2019 to 2023. The breakdown by year is as follows: 54 cases in 2019, 27 in 2020, 47 in 2021, 12 in 2022, and 22 in 2023. Of these crimes, 14 (8.6%) were



This article is published under the Creative Commons
CC-BY License by 4.0, ©2024 University of Internal Affairs, Mongolia

investigated by the Anti-Corruption Agency (ACA), and 148 (91.4%) were investigated by the police. Research and analysis have been conducted on the current state of economic crimes, identifying key issues and drawing conclusions on potential solutions.

Түлхүүр үгс: Мөнгө угаах, гэмт хэрэг, эдийн засаг, гэмт хэргийн шинж.

Key words: Money laundering, crime, economy, elements of the crime.


Удиртгал. Нэгдсэн Үндэсний байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас 2024 оны жилийн эцсээр гаргасан судалгаагаар жил бүр дэлхийн хэмжээнд ойролцоогоор 800-2 их наяд ам.доллар угааж байгаа нь улс орнуудын засгийн газруудын хувьд тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Манай улсын хувьд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”, Иргэний хуулийн 89 дүгээр зүйлд: “Эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ” гэж иргэний өмчлөх эрхийг баталгаажуулан хуульчилсан ч сүүлийн үед мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх нь жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Мөнгө угаах гэмт хэргийг Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс, газрууд өөрсдөө илрүүлсэн хэргийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулан шалгаж байна.

Цагдаагийн байгууллагаас 87 хэрэг буюу 58.8 хувийг Эрүүгийн цагдаагийн алба шалгасан, Мөрдөн байцаах алба 3 хэрэг буюу 2.02 хувийг, нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн газарт 23 хэрэг буюу 15.5 хувийг, орон нутгийн ЦГ 35 буюу 23.6 хувийг тус тус шалгажээ. Гэмт хэргийн илрүүлэлт 24.3 хувь, нийт гэмт хэргийн **120** буюу **74.1** хувь нь далд аргаар үйлдэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 111 буюу 68.5 хувь нь нийслэлд, 51 буюу 31.5 хувь нь орон нутагт бүртгэгдсэн (ЦЕГ, 2023).

Дэлхий нийтэд тархсан ковидтой холбоотойгоор нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 онд өмнөх оноос 50.0 хувиар, 2022 онд 74.5 хувиар буурсан бол, 2021 онд 74.1 хувиар, 2023 онд 83.3 хувиар өссөн. Бүртгэгдсэн гэмт хэргийн **152** буюу 93.8 хувь нь хэрэг бүртгэлтийн хэрэг байгаа бөгөөд үүнээс 149 буюу 92.0 хувь нь хөнгөн, 13 буюу 8.0 хувь нь хүнд гэмт хэрэг, 55 буюу 34.0 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.



Зураг №1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (2019-2023 он)

Мөнгө угаах гэмт хэргийн улмаас 2019 онд 9, 2020 онд 10, 2021 онд 8, 2022 онд 5, 2023 онд 6 нийт 38 иргэн, 3 хуулийн этгээдэд 106.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан бөгөөд эдгээрийг задалж үзүүлбэл:


➤ 2019 онд	2559820000
төгрөгийн,	
➤ 2020 онд	99347670400
төгрөгийн,	
➤ 2021 онд	4699966200
төгрөгийн,	

➤ 2022 онд 72090000 төгрөгийн,
➤ 2023 онд 265065600 төгрөгийн
хохирол учруулсан байна.

Дээрх хохирлоос 2019 онд 2558050000 төгрөгийн буюу нийт хохирлын 99.9 хувийг, 2020 онд 5890000 төгрөгийг, 2021 онд 4003061200 төгрөгийн буюу 85.2 хувийг, 2022 онд 10210000 төгрөгийн буюу 14.2 хувийг, 2023 онд

2865600 буюу 1.1 хувийн хохирлыг тус тус нөхөн төлүүлсэн юм. Өөрөөр хэлбэл, 6.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлсэн хувь 6.1 хувь байна.

2019 онд 1599831320 төгрөгийн, 2023 онд 4000000000 төгрөгийн буюу 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн.



Зураг №2. Учирсан хохирол, сая төгрөг (2019-2023 он)

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2019 онд 32, 2020 онд 9, 2021 онд 35, 2022 онд 6, 2023 онд 22 хүн буюу Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэрэгт нийт 93 хүнийг яллагдагчаар татагдан шалгагдсан бөгөөд тэдгээрийн 64 буюу 68.9 хувь нь нийслэлд, 29 буюу 31.1 хувь нь орон нутагт бүртгэгдэн шалгагдсан.


Мөнгө угаах гэмт хэрэгт яллагдагчдын 11 буюу 11.8 хувь нь БНХАУ-ын иргэд, 29 буюу 31.2 хувь нь эмэгтэй, 5 буюу 5.4 хувь нь банк санхүүгийн ажилтан, 2 буюу 2.2 хувь нь валютын ченж, 16 буюу 17.2 хувь нь ажилгүй, 9 буюу 9.7 хувь нь өмнө нь ял шийтгэл эдэлж байсан хүн байгаа ба мөн гэмт хэргийн 30 буюу 18.5 хувь нь эмэгтэй хүн оролцсон байна.

Хууль сахиулах байгууллагууд мөнгө угаах гэмт хэргийг суурь гэмт хэрэгтэй хамт мөрдөн шалгаж байгаа ч ийнхүү шалгах хугацаанд Монгол Улс эрүүгийн хэрэгт өргөн хүрээнд өршөөл үзүүлж буй нь мөнгө угаах гэмт хэрэгтэй

тэмцэхэд хүндрэл учруулж байна. Мөн байгаль орчны эсрэг, татвараас зайлсхийх гэмт хэрэгт нь мөнгө угаах гэмт хэргийн хувьд өндөр эрсдэлтэй, мөрдөн шалгах ажиллагааны үр дүн хангалтгүй (APG, 2017) гэж дүгнэжээ.

Эдгээр он жилүүдэд мөнгө угаах гэмт хэрэг цөөн шийдэгдсэн нь манай улсын хувьд шинэ тутамд тооцогдох мөнгө угаах гэмт хэргийн талаарх мэдлэг хууль хэрэглэгч болон хэрэгжүүлэгчдийн аль алинд нь бага, тэр дундаа тухайн гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэх практик байхгүй байсантай холбоотой гэж үзэж байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн судлаачид орчин үеийн судалгааны аргын нэг “Системийн динамик загвар (ШУТИС, 2022)-ыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийн төлөвийг “Вензим” программаар регрессийн шинжилгээ хийхэд манай улсад 2040 он хүртэл мөнгө угаах гэмт хэрэг нь санхүүгийн болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан жил тутам 5 хувиар өсөх үр дүн гарчээ.



Зураг №3. Гэмт хэргийн дундаж өсөлт

Энэхүү судалгаагаар манай улсын 10000 хүн ам тутамд мөнгө угаах гэмт хэрэг 2010 онд 0.06, 2020 онд 0.17 тус тус байсан бол, 2040 он гэхэд 0.41 гэсэн үзүүлэлтээр өсөх бөгөөд үүнд хүн амын өсөлт, төсвийн болон санхүү, крипто зах зээлийн тэлэлт шууд нөлөөлөхөөр байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг салбар бүрд зохион байгуулах, үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах тогтолцоо, хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай болох нь тооцоолол судалгаанаас харагдаж байна.

Ийнхүү эдийн засгийн гэмт хэргийн нөхцөл байдлыг судалж үзэхэд төр засгаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, алба хаагчдыг чадавхжуулах ажлуудыг эрчимтэй хийж байгаа хэдий ч энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг судалж, дүн шинжилгээ хийж, практикт тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна.

Энэхүү судалгааг хийхэд эдийн засгийн гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөл, хүчин зүйлийг харьцуулах, тоо баримтад дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, статистик тоон мэдээг үндэслэн тухайн үзэгдлийг тайлбарлаж, гадаадын зарим орны болон дотоодын эрдэмтдийн бүтээлийг харьцуулан судаллаа.

Нэг. Эрх зүйн зохицуулалт. Эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаачид “гэмт хэрэг бол Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашиг, сонирхолд халдаж уршигт үр дагаврыг /хор уршиг/ бий болгосон, ийм үр дагавар бий болохуйц нөхцөл бүрдүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй гэж тодорхойлдог. Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцоход зайлшгүй шаардлагатай объектив болон субъектив шинжүүдийн цогц бүрдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүн гэх бөгөөд гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүд тодорхой гэмт хэргийн мөн чанар, хор аюулын түвшнийг бүрэн тодорхойлохуйц байх ёстой” (Жанцан, 2009) гэж үздэг.

Онолын хувьд гэмт хэрэг “илэрсэн” эсхүл “илрээгүй”-д тооцох үндсэн шалгуурыг гэмт хэрэг үйлдсэн этгээд тогтоогдсон эсэхтэй холбон үздэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд тогтоогдоогүй тохиолдлыг гэмт хэрэг илрээгүйд тооцох ба тухайн тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдсэн боловч, түүнийг хэн үйлдсэн нь тогтоогдоогүй байдаг (Болдбаатар, 1999). Өөрөөр хэлбэл, энэ нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанаар тогтоосон зүй тогтлын дагуу гэмт хэргийн бүрэлдэхүүн бүрэн байж гэмт хэрэгт тооцогддогтой холбоотой байна.

Эрүүгийн хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх

ажиллагааг зохицуулдаг гол хуульд болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017)-д гэсэн нь гэмт хэрэг үйлдэх замаар дээрх эрхийг зөрчсөн болохыг тогтоосны үндсэн дээр хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх тогтоох ажиллагаа явагдах үндэслэл бүрддэг байна.

Тиймээс гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн нэг элемент “субъект” тогтоогдоогүй байх нь Эрүүгийн процессын хуулийн зорилт хангагдахгүй байдалд хүрэх буюу эрүүгийн хэрэг илрээгүйд тооцох үндэслэл болно. Өөрөөр хэлбэл, тухайн үйл явдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг болохыг тогтоох нь гэмт хэрэг илэрсэнд тооцоход хангалтгүй бөгөөд гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай этгээд тогтоогдсон тохиолдолд гэмт хэргийг илэрсэнд тооцох үндэслэл хангагдах нь харагдана.

Даяарчлалын нөлөөгөөр бохир мөнгө угаах зах зээлийн хүрээ өргөжиж энэ асуудал нь дэлхий нийтийн тэргүүлэх тулгамдсан асуудлын нэг болсон билээ.

“Мөнгө угаах” хэмээх нэр томъёоны гарал үүслийн талаар олон янзын хувилбар байдгаас хамгийн их дэлгэрсэн нь 1920-д оны үед АНУ-ын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд “Согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх тээвэрлэх, худалдан борлуулахыг хориглосон” (АНУ-ын Үндсэн хууль, 1920) зүйл заалтыг нэмэлт болгон оруулсан явдал тооцогдох бөгөөд 1933 оны 12 дугаар сард уг зүйл заалтыг

хүчингүй болгосон ч түүхэнд энэ үйл явдал “Хуурай хууль” гэж нэрлэгдэн үлджээ.

Энэ л үеэс согтууруулах ундааны хууль бус бизнесийн талбарыг гартаа авахын төлөө Итали, Ирланд гаралтай гангестеруудын хооронд ширүүн тэмцэл өрнөжээ. Эцэст нь АНУ-ыг газар зүйн байршлаар нь 27 дүүрэгт хуваан тухайлбал, Нью-Йоркийг Сальваторе Маранзаногийн Коза нострагийн бүлэг, Чикагог Итали гаралтай Аль Капоны бүлэг, Флоридаг Мейер Лански бүлэг гэхчлэн хуваан авч согтууруулах ундаа борлуулан энэхүү хууль бус наймаанаас ихээхэн хөрөнгөжжээ.

1988 онд Мансууруулах болон сэтгэцэд гаж нөлөө үзүүлэх бодисын хууль бус наймааны эсрэг НҮБ-ын Конвенц болох Венийн конвенц батлагдан гарсан бөгөөд уг конвенцод анх удаа “мөнгө угаах” нэр томъёог албан ёсоор ашигласан төдийгүй мөнгө угаах ажиллагааг гэмт хэрэгт тооцох тухай тайлбарыг ч хийсэн байна (Мансууруулах болон сэтгэцэд гаж нөлөө үзүүлэх бодисын хууль бус наймааны эсрэг конвенц, 1988).

Ийнхүү 1920-д оны үед АНУ-д “мөнгө угаах” гэдэг нэр томъёолол сонгодог хэлбэрээр анхлан гарч ирсэн бөгөөд 1988 онд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгийг хууль ёсны болгоход чиглэсэн үйл ажиллагааг үйлдлийн аргаар нь “мөнгө угаах” гэж олон улсад албан ёсоор нэрлэх болсон байна.

2000 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн Конвенц батлагдсан бөгөөд энэхүү конвенцод “мөнгө угаах гэмт хэрэг”, “суурь гэмт хэрэг”, “хууль бус орлого”-ын тухай нарийвчилсан тайлбар тодорхойлолтыг өгсөн (Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц, 2000).

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 23 дугаар зүйлд: “Гэмт хэрэг үйлдэх замаар

олсон орлогыг угаах буюу мөнгө угаах гэмт хэрэг гэдгийг Палермогийн конвенцод заасан агуулгаар тодорхойлсон байх ба харин гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон, авсан аливаа эд хөрөнгийг “гэмт хэргээс олсон орлого” гэж ойлгоно (Авлигын эсрэг конвенц, 2005) хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, аливаа гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогыг хууль ёсны болгоход чиглэсэн үйл ажиллагааг олон улсын хэмжээнд албан ёсоор “мөнгө угаах гэмт хэрэг”, харин хууль бус орлого олохын тулд үйлдсэн гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн “суурь буюу үндсэн гэмт хэрэг”-т тооцож байгаа нь илэрхий байна.

Ийнхүү олон улсын эрх зүйн салбарт “мөнгө угаах” нэр томъёог албан ёсоор хэрэглэж эхэлсэн төдийгүй мөнгө угаах болон суурь гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, ялгаатай тал болон “хууль бус орлого” хэмээх нэр томъёоны талаар ч нарийвчилсан тодорхойлолтууд өгч тайлбарлах болсноор мөнгө угаах гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх нэгдмэл ойлголтыг олон улсын эрх зүйн түвшинд бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй байна.

Манай улс 2003 онд Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенцод, 2006 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн конвенцод нэгдэн орж, 2006 оны 07 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай бие даасан хууль батлан мөрдөж эхэлсэн нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны шинэ эхлэл болсон юм (Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013). Энэ хуулийн 3.1.1 дэх хэсэгт: “Мөнгө угаах гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран

зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг хэлнэ” гэж тодорхойлсон ба 2013 онд мөн хуулийг шинэчлэн боловсруулсан нь өнөө хүчин төгөлдөр үйлчилж байна.

Үндэсний эрдэмтэн, судлаачдын хувьд мөнгө угаах гэдэг нь хууль бусаар олсон орлого, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж, уг хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулах өргөн хүрээтэй шат дамжлага бүхий үйл ажиллагаа (Эрүүгийн хууль, 2015) гэж тодорхойлсон нь үндсэндээ олон улсын хэмжээнд заасан томъёололтой агуулгын хувьд нийцэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улс орны эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учирдаг, харин хор уршиг нь нийгмийн гишүүн бүрд учирч байдгаараа онцлогтой.

Хоёр. Тулгамдаж буй зарим асуудал, шийдвэрлэх арга замын талаар. 1. Мөнгө угаах гэмт хэргийн тухайд гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан, нуун далдалсан өөрчилсөн, шилжүүлсэн, захиран зарцуулсан л бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан. Гэтэл манай улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлд: “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн дагуу суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа мөнгө угаах гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх боломж бүрдэхээр зохицуулалттай байгаа билээ. Өөрөөр хэлбэл, суурь гэмт хэргийг нотлолгүйгээр, мөнгө угаах гэмт хэргийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг хууль бус эсэхийг тогтоолгүйгээр мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэх боломжгүй байна. Тиймээс зарим тохиолдолд мөнгө угаах гэмт хэргээр

зүйлчилсэн хэргийн суурь гэмт хэргийг бүрэн дүүрэн тогтоогоогүй учир мөнгө угаасан гэж үзэх боломжгүй гэж шүүхээс үзэж хэрэг мөрдөн байцаалтад буцаах тохиолдол ч байна.

Энэ нь нэг талаараа аливаа иргэн, хуулийн этгээдийг “хилсдүүлэн гүтгэх”-ээс урьдчилан сэргийлж буй чухал зарчмуудын нэг ч нөгөө талаараа мөнгө угаах цаашлаад бусад санхүүгийн төрлийн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

2. Банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь харилцагчдад үйлчилгээ үзүүлэх боловч хуулиар хүлээсэн үүргийн дагуу улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалтыг гарган банк, санхүүгийн байгууллагаар хийсэн гүйлгээг хянаж байгаа ч тэдний шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэх боломж ч хомс байна. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6.1.3-т зааснаар Банк нь Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийгдсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих, мөн хуулийн 3.1.5-д “Улс төрд нөлөө бүхий этгээд” гэдгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд байна гээд тэдгээр нь улс төрийн тодорхой “албан тушаал эрхэлж байсан” болон “эрхэлж байгаа хүн”, эсхүл түүнтэй “хамаарал бүхий этгээд” гэж тодорхойлсон байдаг (Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013) тул үүнтэй холбоотойгоор үүсэж буй гол бэрхшээл нь арилжааны банкнуудын зүгээс Улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий этгээдийг нэг бүрчлэн олж тодорхойлох эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд боломжгүй юм. Мөн тухайн этгээдтэй “хамаарал бүхий этгээд” нь насан туршдаа улс төрд нөлөө бүхий этгээд гэдгээр

тусгайлан хянагдах шаардлагатай болж байна.

Улс төрд нөлөө бүхий этгээдэд хяналт тавих тухай заалтыг тодорхой болгох зорилгоор Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд шаардлагатай өөрчлөлтийг оруулах, эсвэл Монгол банкны Санхүүгийн Мэдээллийн Алба, Авлигатай тэмцэх газар хамтран “Улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийн нэгдсэн сан”-г үүсгэж, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд тус санд нэвтрэх талаар зохих арга хэмжээг авах,

Харилцагчийг таньж мэдэх болон сэжигтэй гүйлгээг таньж илрүүлэх зорилгоор ашиглаж буй программ хангамжийн шүүлтийн дүрмийг хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж оновчтой байдлыг хангахад хууль сахиулах байгууллагын туслалцаа дэмжлэг хэрэгтэй.

3. Хүн төрөлхтөн цахим эрин үе рүү шилжсэнтэй холбогдуулан нийгмийн хөгжлийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, тэдгээрийг үйлдэгчид нийгмийн хөгжлийг даган хувьсан өөрчлөгдөж, цахим орчныг ашиглан гэмт хэрэг үйлдэх нь өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудын нэг болон хувирч байна.

Цахим гэмт хэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүд дотор томоохон байр суурь эзлэх бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6558 буюу 26 хувийг эзэлж байгаа нь 4 гэмт хэрэг тутмын 1 нь кибер орон зайг ашиглан үйлдэгдэж, 2021 онд энэ төрлийн гэмт хэрэг 53,6 хувиар өссөн ба хэргийн илрүүлэлт 48,5 хувь (ЦЕГ, Статистик мэдээ, 2021)-тай байна.

Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зэвсэг болгон ашиглаж болох технологийн дэвшлийн нэг нь хиймэл оюун ухааны технологи бөгөөд хэмээн үзэж байна.

4. Цагдаагийн байгууллагын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлын нэг нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд оролцогч этгээд (төрийн болон хувийн хэвшил) хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо хангалтгүй байгаагаас хуулийн хэрэгжилтэд мөн сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, улсын бүртгэлийн байгууллагын бүртгэлд хамруулах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хүрээнд ирүүлж буй мэдээлэл бүрэн бус буюу хагас дутуу шаардлага хангахгүй байх эсхүл бүр мэдээлэл байхгүй байх ч тохиолдол байна. Энэ нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд үүрэг, хариуцлага, хяналтын тогтолцоо алдагдсан, мэргэшсэн боловсон хүчин байхгүй байгаагийн илрэл юм.

5. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны салшгүй нэг хэсэг болох хөрөнгө буцаах ажиллагааг хууль эрх зүйн түвшин явуулах нь нэн тэргүүний чухал асуудлуудын нэг болоод байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль бус орлогыг татан төвлөрүүлэхэд “Хөрөнгө буцаах ажиллагааг” тусгайлан журамлах эсхүл ЭХХШт хуульд тохирох зохицуулалтыг шаардлагатай байна.

Дүгнэлт:

Манай улс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхдээ мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх онол, арга зүйн үндсийг олон улсын туршлагад тулгуурлан судалж, үндэсний эрх зүйн салбарт нэвтрүүлж эхэлснээс хойш багагүй цаг хугацаа өнгөрсөн нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны тулгамдсан асуудлуудыг нээн илрүүлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрэлхийлэх нь нэн чухал болохыг харуулж байна.

Манай улсын хувьд мөнгө угаах гэмт хэрэг нь харьцангуй шинэ төрлийн

гэмт хэрэгт тооцогдож 2000 оны эхэн үед манай улсад бохир мөнгө угаагдах эрсдэлт нөхцөл байдал үүссэн байна гэж эрдэмтэн, судлаачид дүгнэж байсан бол, бидний хийсэн сүүлийн 5 жилийн судалгаагаар мөнгө угаах гэмт хэргийн тархалт, шилжилт хөдөлгөөн зэргээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэрэг нь манай улсын эдийн засгийн бүх салбарт сонгодог утгаар хэрэгжиж байна. Энэ байдал нь цагдаагийн байгууллагад бүртгэгдэж шалгагдсан мөнгө угаах гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ зэргээс харагдаж билээ.

Иймд манай улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн сөрөг үр дагавар болох ялангуяа, мөнгө угаах гэмт хэргийн шинж чанарт нөлөөлж, шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг шинэлэг байдлаар авч үзэх хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Ашигласан материал

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, (2006 & 2013).
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=9242>.

Эрүүгийн хууль, (2015).
<https://legalinfo.mn/mn/detail/11634>.

Венийн мансууруулах болон сэтгэцэд гаж нөлөө үзүүлэх бодисын хууль бус наймааны эсрэг конвенц. (1988).

Палермогийн Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх конвенц (2000).

Авлигын эсрэг конвенц (Нэгдсэн үндэсний байгууллага 2005).

Болдбаатар, Ж. (1999). *Илрээгүй гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа*. Уб.,.

Жанцан, С. (2009). *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (гэмт хэргийн сургааль)* (Б. II). Уб.,.

ЦЕГ. (2021 & 2023). *Статистик мэдээ*.
<https://police.gov.mn/as/article/3>.

APG. (2017). *Anti-money laundering and counter-terrorist financing measures: Mongolia*. Asia/Pacific Group on Money Laundering.

FATF. (2022). *Мөнгө угаах үйл явц, хэргийн гаралт*. www.fatf-gafi.org.

ШУТИС. (2022). *Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн сисиемийн динамик загвар*.